

ШАВЬ ХҮНД БАЙХ ЁСТОЙ ШИНЖИЙН ТУХАЙ БУДДЫН ГҮН УХААНЫ СУРГААЛ

Н.ХАВХ

МУИС, МХСС, Буддын болон Монголын соёлын сургалт, судалгааны төв

Түлхүүр уг: - Шавийн тууштай шинж (шударга оршигч)

- Сэтгэн бodoх чадвар (оюун төгөлдөр)
- Хичээл зүтгэл (тусыг чухалчлагч)
- Шүтэх үзэл (ном хийгээд ном өгүүлэгчийг бишрэх)
- Санаагаа төвлөрүүлэх (сэтгэлээ талбих)
- Таван шинжийг хэрэгжүүлэх ёсон, арга ухаан

Товч агуулга: Аль ч номонд суралцахад шавь хүнд тавигдах шинж гэж заавал байх ёстой гээд тэрхүү шинжийг эзэмшээгүй, тийм шинж чанаргүй хүн болвоос ямар ч эрдэм ухаанд суралцах, тэгэх тусмаа тэр чиглэлээр амжилт гаргаж чадахгүй хэмээн буддын сурган хүмүүжүүлэх ухаанд сургадаг. Шавь хүнд заавал байх ёстой шинжуудийг эзэмших арга ухаан байх агаад тэр нь юу гэвэл шавь хүн нь ухаалаг хүүхэд мэт, алмаз мэт, дэлхий мэт, үүл мэт, зарц мэт, үйлчлэгч мэт, тэрэг мэт, нохой мэт, хөлөг мэт байх ёстой хэмээдэг аж.

*Шавьд байх ёстой таван
шинж, тэдгээрийн уялдаа,
холбоо*

Буддизмын "Дөсвөн зуут" хэмээх сударт шавийг эрдмийн "сав" хэмээгээд тэрхүү

"сав" нь тууштай туйлбартай, оюун ухаан төгелдөр, оролдлого зүтгэлтэй байх ёстой; тэгвээс багшийн номолсон, гэхдээн ярьсаныг гүйвуулан буруугаар ойлгох явдалгүй байх болно" хэмээсэн байдаг аж¹. Дээрх гурван шинжийг өөртөөн шингээсэн шавь бол багшийн сургаалийг сонсвоос тэр үр өгөөжтэй; ухаарал гэгээрэлд хүрэх бүрэн дүүрэн бололцоотой аж. Хэрэв эдгээр гурван шинжийн аль нэг нь бүрэн гүйцэт бус, дутуу дулимаг байх аваас, багш сургаалаа хичнээн ч сайн номлосон ч, тэрээр эрдэм номонд сайтар суралцаж эс чадна.

1. Шавийн тууштай, туйлбартай шинж (шударга оршигч). Энэ нь үнэн зөв сургаалыг эргэлзэх юмгүй, эргэлт буцалгүй хүлээн авах, худал хуурмаг гаж буруу номлолыг үл тэвчих, таягдан хаях чанар аж. Туйлбартай шинжийн гол нь туйлшралгүй байх, өөрийн урьд өмнөх бодолтойгоо үл зууралдах явдал юм байна. "Би хэмээх сэтгэлд хүлэгдэн уягdsан ухаан хэзээд амар тайван байж эс чадна гээд энэ нь оюун санааны өмнөх уламжлалтай хэт зууралдах, бусдын уламжлалыг хэт үгүйсгэхийг хэлнэ; хэрвээ өөрт чинь

¹ Чже Цонкапа. Большое руководство к этапам пути пробуждения. I, СПБ., 1994, 64 дэхь тал

тийм сэтгэл байна гэдгийг мэдэрвээс, түүнийг олж харваас түүнийгээ зурх сэтгэлээс үтэр зайлцуул¹ хэмээх номлол бий. Энэ угтаан өөрийн хүний хоёрыг, шинэ хуучин хоёрыг, арга билиг хоёрыг ёс номоор нь шүтэн барилдуулахыг; аль нэгий нь туйлшралд эс орохыг, мөнхийн хязгаар, тасархайн хязгаарт эс баригдахыг шавь хүний тууштай, туйлбартай шинж мөн хэмээсэн үг юм байна. Нэг үгээр хэлэхэд өөрийн болон бусдын ном, сургаалд төвч ёсоор, арга билгийг зөвөөр шүтэн барилдуулна гэсэн хэрэг. Зөрчлийг бий болгогч арга, билиг хэмээх эсрэг тэсрэг талуудын ийнхүү шүтэн барилдуулахад дан ганц тууштай туйлбартай шинж хангалтгүй. Үүнийг хэрэгжүүлэхэд шавь нараас оюун ухааны сэтгэн бodoх чадварын нилээд өндөр түвшин шаардлагатай байдаг аж.

2. Төгөлдөр оюун ухаан буюу сэтгэн бodoх чадвар (оюун төгөлдөр). Шавь нарын шинж зөвхөн тууштай туйлбартай шинжээр хязгаарлагдаас "оюун ухаан нь үнэн зөв сургаалыг худал хуурмаг муу номлогоос ялган салгаж үл чадна; шавь эрдмийн "сав" биш; тийм шавь багшийн ном, сургаал ухаан лавшуулан ойлгох чадваргүй нэгэн хэвээр байх болно. "Тийм болохоор төгөлдөр оюун ухаан, сэтгэн бodoх чадвартай байхаас өөр замгүй; тэгснээр юмын цаад учрыг танин мэднэ, утга учиргүйг нь орхин гээнэ, гол чухлыг нь авч хоцорно². Чухамдаа энэхүү төгөлдөр оюун ухаан буюу зөв сэтгэн бodoх ухаанаар дээр өгүүлсэн туйлшралыг эс үзнэ; өөрийн үзэлтэй хэт эс зууралдана, бусдын бодлыг ор тас эс үгүйсгэнэ; өөрийн, хүний хоёроос буруу бүхнийг орхин гээнэ; үнэн зөв бүхнийг нь авч хоцроно; хоцрохоор барахгүй тэдгээрийг буддын гүн ухааны хэлээр бол арга билиг хоёрыг, мөнх тасархай хоёрыг шүтэн барилдуулна; шүтэн барилсан шинжийг олно, түүнийг ухааран ойлгоно.

3. Хичээл зүтгэл (тусыг чухалчилагч). Ном эрдмийг амжилттай сурахад тууштай туйлбартай, төгөлдөр оюун буюу зөв сэтгэн бodoх хэмээх энэ хоёр шинж нэн чухал хэдий ч хангалтгүй байдаг аж; учир нь суралцах хөдөлмөр нь байнгын оролдлого чармайлт, уйгагүй зүтгэлийг шаардана; үүнийг буддын гүн ухаанд тусыг чухалчлагч буюу хичээл зүтгэл хэмээсэн байх аж; зүй нь гэхэд аль нэгэн чиглэлээр сэтгэл төрүүлэх, төрүүлсэнээ тогтоох, тогтоосноо лавшуулах, лавшуулснаа тогтоон барих гэх мэт шатаар хийх бясалгалын аль ч шатанд бодлоо төвлөрүүлэх дасгалыг дахин давтан хийж байж сая уг сэтгэлийг үүсгэнэ; аль чигийн бясалгалыг тууштай хичээнгүйгээр зүтгэхгүйгээр хийнэ; хийж амжилтанд хүрнэ гэж үгүй. Мөн хичээнгүйгээр зүтгэхгүйгээр хийнэ; хийж амжилтанд хүрнэ гэж үгүй. Мөн

¹ Мөн тэнд, 39-56 дахь тал


² Чже Цонкапа. Большое руководство к этапам пути пробуждения. I, СПБ., 1994. 65 дахь тал

"<<Тайлбар>> сударт шавь зайлшгэй эзэмших ёстой таван шинжийн тухай өгүүлсэн байдаг; тэр нь юу билээ гэхлээр үүний өмнө өгүүлсэн гурван шинж дээр багш ном хоёрыг шүтэх, бодол санаагаа төвлөрүүлэх чадал хэмээх хоёр шинж нэмэгдэнэ."¹

4. Багш, ном хоёроо шүтэн дээдлэх (ном хийгээд ном өгүүлэгч дор бишрэх)

5. Бодол санаагаа төвлөрүүлэх чадвар (сэтгэлээ талбих). Сэтгэлийг бий болгох, үүсгэх; сэтгэлийн хөөрөл хөдөлгөөнийг ухааны жолоодлогонд оруулах шилдэг сонгодог, бараг цорын ганц, гэж болохоор арга бол бясалгал; бясалгал нь бодь сэтгэлийг үүсгэх, зөв сэтгэхүйг тогтоох гэж шат дараалсан хоёр хэлбэртэй байдаг. Хэрэв дээрх шинжүүд шавь хүнд бүрэн гүйцэт байх авбаас түүнд ном зааж эхлэх; дутуу байх авбаас түүнийг гүйцэх талаар анхаарал тавих, гүйцээсний дараа ном зааж эхлэх ёстой аж. Шавьд байвал зохих дээр өгүүлсэн 5 шинж өөр хоорондоо ямар ч холбоогүй, бие биенээсээ шалтгаалах юм үгүй, саланг тусдаан байх шинжүүд биш байх; холбоотойгоор барих тэдгээр шинжүүд шавиас багшийн номыг сонсох сурахад өөр өөрийн үүрэгтэй байх ёстой хэмээн үзэх ёстой болов уу. Зүй нь гэхэд бодол санаагаа төвлөрүүлэх чадвар нь сэтгэлийг үүсгэх, тухайн тохиолдолд багшаа, номоо дээдлэх сэтгэлийг бий болгоход голлох үүрэгтэй болов уу; учир нь сэтгэл санаагаа төвлөрүүлэхгүйгээр сэтгэлийн хөдөлгөөнийг шаардагдах зүгт нь залах бололцоогүй гэдэг. Багш, ном хоёроо шүтэхгүйгээр хичнээн ч хичээл зүтгэл гарваас тэр нь буруу хүний буруу номыг сурах эрч хүч эрмэлзэл тэмүүлэл болох ч тохиолдол бий. Багш ном хоёроо шүтэн дээдлэхгүйгээр хичээл зүтгэлгүй байх аваас хичнээн ч чадвартай, төгөлдөр ухаантай, хичнээн ч тууштай туйлбартай байлаа ч тэр бүхэн нь эрч хүч, зүг чигээр дутагдах, шавь эсдэм номын "сав" болж үл чадна. Шавь хүнд байх ёстой 5 шинжийн хамаарлыг зургаар илэрхийлвээс:

(Зураг №1)



- (1) Бодлоо төвлөрүүлэх чадвар, бясалгал
- (2) Багш, ном хоёроо шүтэх сэтгэл
- (3) Туйлбартай байх шинж
- (4) Төгөлдөр оюун ухаан
- (5) Хичээл зүтгэл

↖ - үүсэх зам

¹ мөн тэнд. 65 дахь тал

Зурагт харуулсан шавь хүнд байх ёстой шинжийн дарааллаас юуг шавийн гол шинж бол санаа бодлоо төвлөрүүлэх буюу сэтгэлийн хөөрөл хөдөлгөөнөө ухааны жолоодлогонд оруулж сэтгэлийн бузрыг арилгаж холбогдох чиглэлээр бодь сэтгэлийг, тухайн тохиолдол багш ном хоёрыг шүтэн дээдлэх сэтгэлийг төрүүлэх явдал мөн; багшаа, номоо дээдлэх, хүндлэх улмаар шүтэх сэтгэл бий болчихсон тохиолдолд шавь хүн багшийн номолсон сургаалыг эргэлзэх юмгүй сурна, сонсоно, гэхдээ энэ бүхнийг эрүүл саруул ухаанаар, бүтээлчээр сонсох учиртай аж; бүхнийг зөвхөн өөрийн бодолд тааруулахыг зорих, бусдын бодлыг ор тас үгүйсгэхийн аль алинаас татгалзах, аль алины нь туйлшралд эс орохыг, харин ч аль алинаас нь хэрэгтэй бүхнийг авч өөр хооронд нь шүтэн барилдуулах чадварыг туйлбартай байх шинж хэмээсэн байна; шавийн ийм чанар, чадвар, түүнд багшийн сургаалыг өөрийн болгон бүтээлчээр ойлгох, тэгснээр түүнийг цаашид аривжуулан хөгжүүлэх нөхцөл бололцоог бүрдүүлнэ; үүний тулд, шавь хүн нь төв ёсны сэтгэлгээтэй арга билгийг шүтэн барилдуулах чадвартай байх ёстой аж, түүнийг шавь хүний төгөлдөр оюун ухаантай байх шинж гэсэн юм байна. Хэрэв хичээлгүй, зүтгэлгүй авбаас шавьд дээрх шинжүүд сайтар төлөвшиж эс чадна; ер нь бараг төлөвшихгүй байх.

**Таван шинжийг
хэрэгжүүлэх есөн
арга ухаан**

Есөн арга ухаан хэмээх нь шавь нар өөрт нь нэгэнт үүсэн төлөвшиж тогтсон дээр өгүүлсэн таван шинжийг суралцах үйл ажиллагааны практик амьдралд хэрэгжүүлэхэд барьж мөрдөх бодол санаа аж. Тэдгээр нь шавь хүн дараах 9 зүйлийг баримтлан мөрдөх ёстой журам, арга ухаан. Үүнд (1) Ухаалаг хүүхэд мэт байх, (2) Алмаз мэт байх, (3) Дэлхий мэт байх, (4) Уул мэт, (5) Зарц мэт байх, (6) үйлчлэгч мэт байх, (7) Тэрэг мэт байх, (8) Нохой мэт байх, (9) Хөлөг мэт байх эдгээр болно.

Дорно дахины тэгэх тусмаа буддын гүн ухаанд дүйцүүлэн дүрсэлсэн нэр томъёог өргөн хэрэглэдэг; зүй нь гэхэд аливаагийн нэн тогтвортой шинжийг мод, нэн хувьсамтгайг нь ус, хувьсамтгай нь давамгайлсныг нь төмөр, тогтвортой нь давамгайланыг гал, тогтвортой хувьсамтгай хоёр тэнцвэртэй шүтэлцсэнийг нь шороо хэмээн 5 махбодын онолд томъёолно; Түүний нэгэн адил, энд шавь хүнд байвал зохих, үүний өмнө өгүүлсэн 5 шинжийг хэрэгжүүлэх 9 арга ухааныг тус бүрд нь дуурайн дүрсэлсэн, адилтган дүйлгэн хүүхэд, алмаз, дэлхий уул, зарц, үйлчлэгч, тэрэг, нохой, хөлөг гэх мэтээр томъёолсон нь энэ буюу. Шавьд байх 5 шинжийг хэрэгжүүлж, багшийн номолсон сургаалыг үр өгөөжтэй өөрийн болгоход

дээрх 9 арга ухаан өөр өөрийн гэсэн үүрэг рольтой байх учиртай болов уу.
Үүний тухай дор товч өгүүлэх болно. Үүнд:

1. Ухаалаг хүүхэд мэт байх. "Өөрийн хүсэл тэмүүллийг хойш тавьж, багшийн мэдэлд өөрийгөө тэр чигээр нь өгөхийг, өөрөөр хэлбэл, ухаалаг хүүхэд үйл хөдөлгөөнийг өөрийнхөөрөө биш, эцгийнхээ царайг харж түүний аяыг дагаж хийдэгтэй адил байхыг шавийн ухаалаг хүүхэд лүгээ адил байх арга ухаан гэдэг аж; шавь багшийн аяар байна гэсэн үг"¹ шавь хүн "ухаалаг хүүхэд" болохын хувьд багшийн номолсон сургаалыг ёс номоор нь үг дуугуй сурч эзэмших ёстой аж, тэгвээс үүний өмнөх дэд гарчигт өгүүлсэн шавь хүнд заавал байх ёстой бодлоо төвлөрүүлэх, багш нсм хоёроо дээдлэх, тууштай туйлбартай байх, зөв сэтгэн бодох, хичээл зүтгэл хэмээх 5 шинж амьдрал дээр бүрэн гүйцэт хэрэгжих учиртай юм байна; багшид энэхүү 5 шинж бүрэн бүтнээрээ бий. Есөн арга ухааны үлдсэн найм нь ч мөн л шавьд байх ёстой 5 шинжийг шавь нарын суралцах хөдөлмөрийн практикт хэрэгжүүлэх шилдэг сайн арга болдог юм байна. Ер нь өөрийгөө өвчтөн, багшийгаа эмч, сургаал номоо эм, суралцах хөдөлмөрөө эмчилгээ хэмээх сэтгэлийг өөртөөн гүн бат суулгаж чадсан шавь хүн багшийн сургаалыг "ухаалаг хүүхэд лүгээ дуурайн сурах нь, багштайгаа алмаз лугаа бэх бат холбогдох нь, багшийн өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэхдээн дэлхий мэт үл хотойх нь, уул мэт бат суурьтай байх, зарц мэт үнэнч, үйлчлэгч мэт дорд, тэрэг мэт даацтай, нохой мэт хүлцэнгүй байх, хөлөг мэт үл цуцах нь гарцаагүй үүнээс өөр зам хувилбар гэж үгүй хэмээсэн сургаал юм байна.

2. Алмаз мэт байх. "Багштайгаа байнгын, хэзээ ч үл тасрах бат бэх холбоо тогтоох; тэр нь муу нөхөд хүмүүсийн язуулгаар хэзээд үл тасрах; сударт өгүүлсэнээр багш, шавь хоёр хоёулээ нөхөрлөлдөө эргэлзэх, нөхөрлөлөө супруулахаас нэн болгоомжилвоос зохино"² хэмээн сургасан нь бий. Багш шавь хоёрын барилдлага нь алмаз лугаа бат бэх, үнэ цэнэтэй, ариун тунгалаг байх ёстой юм байна.

3. Дэлхий мэт байх. Суралцах, ухаарах, тэгээрэх хөдөлмөр болвоос урт удаан хугацаагаар үргэлжлэх нөр нөсөр ажил; түүний хирээр багш хүн шавьдаа хүч хөдөлмөр ихээр шаардсан нөр нөсөр даалгавар өгч, шавь нь түүнийг бүрэн дүүрэн хийж гүйцэтгэж, биелүүлж байж сая багшийн эрдэм ухааныг сайтар сурч эзэмшинэ; ухаарал гэгээрлийн замаар итгэл төгс явна. Багшийн өгсөн үүрэг даалгавар нь хичнээн ч хүнд, нөр нөсөр байлаа ч, шавь

¹ Чже Цонкапа. Большое руководство к этапам пути пробуждения. I, СПБ., 1994, 67 дахь тал

² Чже Цонкапа. Большое руководство к этапам пути пробуждения. I, СПБ., 1994, 68 дахь тал

хүн түүнд "дэлхий лүгээ" үл хотойх, өөрөөр хэлбэл, нэр хөдөлмөрийг хийх "дэлхий лүгээ үл хотойх" сэтгэлийн тэнхээтэй байх учиртай аж.

4. Уул мэт байх. Энэ тухай "Их бодь мөрийн зэрэг"-т "Ямар ч зовлон бэрхшээл тохиолдлоо чиг гэсэн бүү гуйвж дайв. Ном сурх үед ямар ч бэрхшээл тохиолдож болно; тэрхүү бэрхшээлээс шантарч, биеийн амрыг харж өмнөө тавьсан зорилгоосоо ухарваас тэр шавь шавь биш болно; хэзээд ч ухаарч гэгээрч эс чадна. Харин ямар ч бэрхшээл тохиолдлоо ч багшийн сургаалыг сонсох, ухаарах гэгээрэх зорилгондоо "уул мэт" бат бөх байж чадваас тэрээр шавь шиг шавь болно.

5. Зарц мэт байх. Багшаас ном эрдмийг нь сурч л байвал, ямар ч хар бор, заваан бохир ажлыг хийж сурх ёстай гэнэ. "Шаардлага гарах авбаас ямар бохир заваан ажлыг ч хамаагүй хийж"¹, барлаг зарц лугаа адил байх учиртай юм байна.

6. Үйлчлэгч мэт байх. Шавь хүн хэзээд ч өөрийгөө багшаасаа доогуур тавьж дорд байлгах тийм сэтгэлийг төрүүлсэн байх учиртай аж. өөрийгөө багшаасаа ямар нэгэн хэлбэрээр, хэмжээгээр дээгүүр тавьбаас тэрээр багшаа, багшийн сургаал номыг шүтэн бишрэхгүй тийм хүн ном сурч чадахгүй. Харин өөрийгөө үйлчлэгч, багшийгаа дээдэс хэмээх сэтгэлийг өөртөөн бий болгосон тэр хүн шавь шиг шавь мөн аж.

7. Тэрэг мэт байх. Шавь бол багшийн өгсөн үүрэг даалгавар хичнээн чиг нэр нөсөр хүнд бэрх байлаа ч, түүнийг заавал хийж гүйцэтгэж чаддаг чадах хүчтэй, сэтгэлийн тэнхээтэй, ямар ч хүнд ачаа барааг даагаад явчихдаг даац ихтэй "тэрэг мэт" байх ёстай аж.

8. Нохой мэт байх. "Багш чамайг басамжилж, харааж байлаа ч битгий уурла. Хэрэв чи ном сургаалаар ангаж, цангаж байгаа л юм бол багш чинь чамаас өө сэв хичнээн ч эрлээ чамайг, үл ойшоолоо ч бүү дургүйц. Харин ном сургаалдаа улам шамд, багш ном хоёрыг шүтэн дээдлэх сэтгэлээ улам лавшуул; багшийнхаа араас цуцалтгүй дагаад яв;"² өөрөөр хэлбэл эзэн нь хичнээн ч хараавч; эznээсээ үл салах эзэндээ үнэнч нохой мэт байх ёстай аж.

9. Хөлөг мэт байх. Ном эрдэм сурх олон жилийн урт замын нэр нөсөр хөдөлмөрийг эцэж цуцахыг мэдэхгүй, үзэхгүйгээр "хөлөг онгоц" лугаа туулах шавийн чадвар, арга ухааныг ийнхүү томъёолсон юм байна.

Ашигласан ном зохиол

¹ Мөн тэнд, 69 дэхь тал

² Мөн тэнд, 70 дахь тал

1. Чже Цонкапа. Большое руководство к этапам пути пробуждения. I, СПБ., 1994
2. Н.Хавх. Буддын сурган, сэтгэл судлал. Хүмүүжлийн гүн ухаан. УБ., 2006
3. Богд Зонхов. Бодь мөрийн зэрэг. Корея.,2002

Резюме

Безусловно, должны быть критерии и тончайшем образом, разработанная методика подбора желающихся учиться по той или иной специальностью. В буддизме имеется, так называемая область знания "Винай" (буддийская педагогика), где рассматривается педагогическое учение, истинность которого проверена на практике в течении много тысяч лета и в настоящей статьи речь идёт об этом учении.